

ЭРДЭНЭЦАГААН СУМ

2021 ОНЫ 11 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Хууль эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн ХШҮ-дотоод аудитын хэлтэс удирдамжийн дагуу 11 дүгээр сарын 01-02 ны өдрүүдэд ЗДТГ болон төсөвт байгууллагын 2021 оны үйл ажиллагаанд 11 хүний бүрэлдхүүнтэй комисс шалгалт хийв.

Аймгийн Статистикийн хэлтсийн даргаар ахлуулсан бүлэг суманд Шинээр томилогдсон 8 багийн Засаг дарга, ХАА-н тасаг, Санхүү алба, ААНБ-ын тооллогын тоологч, сумын удирдлагуудыг оролцуулсан нэг өдрийн сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Онцгой байдлын газрын дарга, Нэгдсэн эмнэлгийн дарга, МХГ-ын улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй бүлэг 2 өдөр ажиллаж Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлыг хянан шалгаж үнэлэлт дүгнэлт өгөв.

Сумын хүн амыг 3-р тун вакцины хамрагдалтыг эрчимжүүлэх зорилгоор сумын засаг даргын 2021 оны 11 сарын 02-ны өдрийн А/195 тоот захирамжаар БЗД, их эмчийн бүрэлдэхүүнтэй 8 хэсгийг томилон уралдаан зарлан ажиллаж байна. Одоогоор вакцины хамрагдалт 34 хувьтай байна.

ЗДТГ-ын албан хаагчдын үйл ажиллагаанд удирдамж гарган ДХШ-ыг хийж дүгнэлт гаргав. Үүнд аймгийн ХШҮ-ний шалгалтын өгсөн зөвлөмжийн дагуу ямар ажил хийж гүйцэтгэж байгааг судлаж үзэв

Монгол улын Засгийн газрын 138 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Сумын Тамгын газрын даргын 2021 оны 11 сарын 10-ны өдрийн А/28 тушаал гарч аймгийн Цахилгаан холбоотой хамтран олон нийтийн сүлжээ /Фэйсбүүк инстаграм, youtube/ хааж мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажилласан.

Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:

Erdenetsagaan.su.gov.mn вэб сайтын доторх функцыг өөрчлөн ажилд оруулж сайтад байх шаардлагатай цонхыг нэмж стандартын дагуу болгон мэдээллийг оруулж ил тод байдлыг ханган ажиллаж байна.

ERP систем ашиглалтыг сайжруулах зорилгоор өдөр бүр нэвтэрч төрийн албан хаагчдыг хоорондоо мэдээ тайлан, бичиг цаасыг системээр дамжуулан солилцож байна.

Сумын хэмжээнд төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд төсөвт байгууллагуудыг нэвтрүүлэх явц 86.0% гүйцэтгэлтэй явж байна.

E-Mongolia.mn, Төрийн үйлчилгээний цахим системээр төлбөртэй 1, төлбөргүй 7 үйлчилгээг 26 иргэнд үзүүлж 8.0 мян ₮ орлого төвлөрсөн байна.

Сумын Коронавирусээс урьдчилан сэргийлэх тандалт судалгааны багт бүртгэгдсэнээр 2021.11.23-ны өдрийн байдлаар нийт батлагдсан тохиолдол 568 байна. Үүнээс эдгэрч гарсан 551 хүн байна.

Төсөв санхүү, статистик : Үйл ажиллагааны орлого – 14647156.70, Хөрөнгийн орлого – 48276850.48, Шууд бус орлого – 8735119.10, Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого – 2185000, Бууны албан татвар -1950000, Малд ногдуулах албан татвар-114833400, Улсын тэмдэгтийн хураамж- 2794100, Түгээмэл тархацтай ашигт малтмалын- 7217956, Хог хаягдлын хураамж – 1842390, Газрын төлбөр -7682530.40, Ус рашаан ашигласаны төлбөр-7778892, Байгалийн ургамал ашигласаны төлбөр 45897108, Бусад татвар – 20000, Бусад орлого – 56772913, Торгуулын орлого – 31211500 тус тус орлого орж нийт 351844915.68 төгрөгийн орлого төвлөрүүлэн орлогын төлөвлөгөө 11 сарын байдлаар 56.2 % , Аймгаас авах санхүүгийн дэмжлэг 445711800 төгрөг авсанаас орон нутгийн 3-н төсөвт байгууллагуудад 11-н сарын байдлаар 801305300 төгрөгийн санхүүжилтийг олгож ажилласан.

Төсөвт 9-н байгууллагын 1-11 сард 1772 ширхэг гүйлгээгээр 9,429.5 сая төгрөгийг зарцуулалтыг анхан шатны баримтын хянан шалган баталгаажуулан ажиллаа

Аудитын байгууллагад 2020 оны төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангийн хүрээнд акт 5, албан шаардлага 1, зөвлөмж ирсэний дагуу түнний хүрээнд авах арга хэмжээний 11 заалт бүхий төлөвлөгөөний биелэлтийг гаргаж хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн албан тоотоор Сүхбаатар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлэн ажилласан. Төсвийн гүйцэтгэлийн болон өрийн мэдээг нийт 7 төсөвт байгууллагаас авч программд шивж бүртгэл хөтлөн мөн улирлын төсвийн гүйцэтгэлийн тайланг өгч өрийн мэдээг сар бүрийн 03-ны дотор программд шивсэн

2021 оны шилэн данс хөтлөлт 80.1%-тай байна.

Сар бүрийн аж үйлдэврийн мэдээг 2 ААНэгж, 6-н иргэнээс сар бүр авч 18 мэдээг хүргүүлэн ажилласан. Улсын хэмээний ААНэгж хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тооллогыг 113 ААН, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн 43 иргэний судалгааг гаргаснаас 106,-ААН, 65-ХХЭ тус тус хамрагдсан.

Худалдаа үйлчилгээ: Сум хөгжүүлэх сангаас 2020 онд 10.0 сая төгрөгийн зээл авсан 1 иргэн зээлээ бүрэн төлж барагдуулсан.4 иргэнд мэдэгдэх хуудас өгсөн.

Аймгийн МХГ-н хүнсний эрүүл ахуйн байцаагчтай хамтран хүнсний 3 дэлгүүрт хяналт шалгалт хийж гарсан зөрчлийн газар дээр нь заавар зөвлөмж өгч ажиллаа.

Өвлийн идэш арга хэмжээг иргэдэд мэдээлэл хүргэж 2 машин 23 тн мах Улаанбаатар хотруу явсан.

Байгаль орчин аялал жуулчлал: Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Бадмаараг хаш”, Эрдэнийн босго ХХК, Андын илч ХХК, Эрээн толгой ХХК-уудтай уулзалт хийн гэрээний биелэлтийн талаар хүсэлт шаардлага тавьж, Эрдэнийн босго ХХК-д албан шаардлага хүргүүлж, хариуг авч ажиллалаа. Гэрээний дагуу зам засварын ажил хийж буй “Бадмаараг хаш”, Андын илч ХХК-ны ажил байдалтай газар дээр нь танилцав. Бичигтийн

боомтоор 2021 онд хэдэн тн ашигт малтмал гарсан талаарх мэдээ судалгааг гаалийн байгууллагад хүсэлт гарган компани тус бүрээр нь авсан.

Сумын нутаг дэвсгэрээр дамжин тээвэрлэлт хийж буй Алаг тогоо ХХК, Дорнын чулуулаг ХХК, Нагааранз ХХК, Олгой булаг ХХК-ны удирдлагуудтай 11 сарын 17-нд уулзалт хурал хийн замын эвдрэл, хог хаягдал, маршрутын дагуу явах, засмал зам тавих зэрэг шаардлагуудыг хуулийн дагуу тавьж 2022 оны 3-р сараас засмал замын ажил эхлэхээр болов. Мөн замын эвдрэл ихтэй Жаран, Хадтай ширээгийн урд тал, Ганцын урд талын замуудыг засварлуулсан. Хэлэлцсэн асуудлуудыг хийж хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлагыг Компани тус бүрт хүргэж ажиллав.

Хог хаягдлын гэрээний дагуу Эрээн толгой ХХК-аас ковш гаргаж сумын нэгдсэн хогийн цэгийг цэвэрлэхээр боллоо.

Амьтны аймаг,ТББ гамшгийн чиглэлээр:Сумын цагдаагийн байгууллагатай хамтарч “Хууль бус ан, зэвсэг 2021” аны хүрээнд цагаан зээрийн эргүүл хяналтын ажлыг 2 удаа зохион байгуулж 1 зөрчил илрүүлж МХГ-т шилжүүлсэн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлдэг Зотол-Өргөө, Есөн дүнчүүр дэлгүүрүүдэд 2 удаа хяналт хийсэн. АДЗ-ийн хурлыг сард 2 удаа хийн асаргааны сунгалт, оршуулыгн тэтгэмжүүд болон ХЭБ авагч өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийн ажил хөдөлмөр эрхлээгүй 14 иргэнийг өрхөөс түтгэлзүүлсэн. Хүүхдийн мөнгөнд шинээр хамрагдах хүсэлт гаргасан 16 хүүхэд бүртгэсэн. 2018-2020 онд малжуулах болон ХБИ, ажлын байр дэмжих, ахмадын төсөл хөтөлбөрт хамрагдсан хугацаа хэтрэлттэй 5 иргэнд мэдэгдэх хуудас өгч бусад хөтөлбөрт хамрагдсан иргэдэд утсаар эргэн төлөлтөө хийх тухай мэдэгдсэн. Шинээр гарсан ажлын байранд одоогоор 75 иргэн бүртгэж 45 иргэнийг зуучилсан.

ХАА,Газар тариалан: Аймгийн засаг даргын А/165 захирамжийн дагуу 5474 толгой малд ангилалт хийж, бүртгэл мэдээллийн санд оруулсан. ХАА-н газрын МАА-н хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг хөдөөгийн 1,3-р багт 2 хоног ажилласан. Мэргэжлийн хяналтын газраас ирсэн зөвлөмжийн хариуг цаг хугацаанд хүргүүлсэн.

Төрийн мэдлийн богийн хээлтүүлэгч 26 хуцыг 10 сарын 10 нд малчдын хүсэлтээр олгосон. 10 ишгэн ухна, 20 хурган хуцыг шинээр тавьсан.

Хөгжлийн бодлогын хэлтэст өвөлжилтийн 07 албан даалгаврын дагуу гаргасан эрх зүйн баримт бичгийг тайлангийн хамт хүргүүлсэн.

Өвс тэжээлийн нөөцөд 5000 боодол өвс, Бор өндрийн хадлангаас 1300 өвсийг 2,3,4,5,6,8-р багийн малчин иргэдэд олгосон.

ХХААЯ, ХААИС-аас зохион байгуулсан “Бэлчээрийн ургамал, хөрс хамгаалал” “хадлан тэжээл бэлтгэлт” сэдэвт 5 хоногийн цахим сургалт, аймгийн ХХААГ-ын мал аж ахуйн хэлтсээс 8 цагийн цахим сургалтанд суусан.

ХАЗНХ-ын бодлого: Явуулын номын сангийн ном уншлага аяны хүрээнд ЗДТГ-ын 17 албан хаагч ном авч уншсан байна. Хүүхэд хамгааллын сайн дурын ажилтан бэлтгэх

үндэсний цахим сургалтанд ЕБС-иас 3 багш, 1-р цэцэрлэгээс 3 багш, ЗДТГ-аас 1 албан хаагч нийт 7 албан хаагч хамрагдсан.

2021 оны байдлаар нийт үрчлэлт хийгдсэн 4 хүүхдийн судалгааг гаргаж ГБХЗХГ-т хүргэсэн.

Ковид-19 цар тахлын онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын сайн дурын бүлгийн бэлэн байдал, хариу арга хэмжээний тайланг 14 асуумж бүхий хүснэгтийн дагуу 14 хоног тутамд байгууллагуудаас авч нэгтгэн гаргаж ГБХЗХГ-т явуулж байна.

Хүүхэд хамгаалал, гэр бүлтэй холбоотой 5 иргэнд утсаар болон биечлэн зөвлөгөө мэдээлэл өгөв.

ХАӨМС-д засуулах 3 хүний мэдээллийг дээд байгууллагад хүргүүлэв. Статистикийн хэлтсээс 2 удаагийн нийт 44 өрхийн тодрууллага гаргуулсан. Дүйцсэн хөтөлбөрт 7 иргэн хамрагдаж байна.

ЕБС: Аймгийн биеийн тамир спортын газраас зохион байгуулсан “Цахим гимнастрада” аэробик гимнастикийн 12-15 насны төрөлд сурагчид амжилттай оролцож 3-р байр эзэлсэн. БМДИ-ын захирал Ж.Болормаа багшийн цахим сургалтанд багш хамрагдсан.

Багшийн ур чадвар, хөгжлийг дэмжих, шилдэг арга зүй, технологийн сан бүрдүүлэх, тэргүүн туршлагыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор багш нарын дунд 21 хоногийн аянг зарлаж агуулгын хоцрогдолтой холбоотой эцэг эх, сурагчдад зориулсан зөвлөмж, хэвлэмэл материалыг бэлтгэн хүргэж ажиллаж байна.

БЦГ-ын хамгаалалтын захиргаа БОЯ-наас зохион байгуулж байгаа шилдэг эко клуб шалгаруулах уралдаанд Биологи эрүүл мэндийн багш клубын сурагчдын хамт Дарьганга суманд очиж эко клубын бүтэн жилийнхээ ажлыг тайлагнаж 1-р байр “шилдэг эко клуб”-ээр шалгарсан.

Боловсрол 100 жилийн хүрээнд багш нар нээлттэй хэлэлцүүлэгт хичээлүүдийг заасан. 10-аас дээш жил ажилласан багш нарын үзүүлэх хамтын хичээлүүд заагдаж байна.

Хүүхэд хамгааллын статистик тоон мэдээлэл гаргах арга зүй сургалтанд 25 багш хамрагдсан.

ХГБХГ, Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоотой хамтран сургуулийн хүүхэд хамгааллын баг, анги удирдсан багш, дотуур байрын багш нарт ажлын байранд стресс бууруулах үе тэнгийнхний дээрэлхэлтэнд өртсөн хүүхдүүдийг хэрхэн танин мэдэх, хүүхэд хүмүүжүүлэхэд хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэх нь цахим сургалтанд нийт 27 багш, эцэг эхчүүдэд зориулсан цахим сургалтанд 21 эцэг эх хамрагдсан.

Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар интрепренершип боловсрол олгох төслийн ЕБС-ийн 8-12-р ангийн нэг бүлэг сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Сургуулийн орчинд сурагчдын оролцооны байгууллагуудыг идэвхжүүлэх оролцооны байгууллагаар дамжуулан сурагчид бие биедээ нөлөөлөх үлгэр дуурайлал үзүүлэх, нийгмийн идэвх хөгжил оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор сурагчдын өөрөө удирдах зөвлөлийг ажиллуулж, Дэлхий даяар алдаршсан Jerusalema чөлленжид дасгал хөдөлгөөнөөр дамжуулан дархлаагаа дэмжих зорилгоор нэгдэж бусад оролцооны

байгууллагуудыг уриалан эхлүүлж ажиллаж байна. Үүнд сургуулийн эко клуб болон өсвөрийн эмч клубууд нэгдээд байна.

Сургуулийн нийт сурагчид багш ажилчдын дунд бие биедээ урам өгөх сэтгэлийн үгээ болон талархсан сэтгэлээ илэрхийлэх “сэтгэлийн илгээмж” хайрцаг аялуулж, “хүүхдийн соёл хүндлэх мэндлэх ёсноос эхтэй аян”-ыг зохион байгуулж байна.

Хүүхдийн 2-р цэцэрлэг: Хөгжмийн дугайланд ахлах бүлгийн 5, бэлтгэл бүлгийн 10 хүүхдийг сонгон авч энгийн хөгжмийн зэмсгийг хүүхэд багачуудад зааж сургаж байна.

Сургалтын орчинг сайжруулах зориолгоор 3 бүлэгт 9 ширхэг хөшиг өөрсдийн ажилчид оёж, 4 бүлэгт стандартын гар нүүр угаах угаалтуур, цахилгаан пойлууртай болгож хүүхдийн гар нүүрийг бүлээн усаар угаах нөхцлийг сайжрууллаа.

Дотоод хяналт шалгалтын нэгж 2 удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж 2 бүлгийн багшийн ажил сайжруулах зөвлөгөө өгч ажиллаа.

Байгууллагын өвөлжилтийн бэлэн байдлыг ханган нүүрс 160 тн, хөрзөн 4 тн татаж бэлтгэсэн. Байгууллагын эргэн тойронд их цэвэрлэгээ хийж 2 тн хог болон нүүрсний 8 тн хогийг төвлөрсөн хогийн цэгт хаясан.Зөөлөн эдлэлийг бүрэн шинэчлэн бүлэг бүрт хүлээлгэн өглөө.

Хүүхдийн 1-р цэцэрлэг: Халдвараас сэргийлэх зөвлөмж 6 бүлгийн 140 эцэг эхэд тогтмол өгч байна 7 бүлгийн 17 багш хамтран 1200 ш хэрэглэгдэхүүний үзэсгэлэн гаргасан. Бэлтгэл бүлгүүд хамтран “Адтай жаалууд” өдөрлөгийг зохион байгуулан 1-р улиралд үзсэн дуу, шүлэг бүжгийг эцэг эхчүүддээ цахимаар үзүүлэв. Уг арга хэмжээнд 3 бүлгийн 61 хүүхэд орлцож, 3 шүлэг, 5 дуу, 1 бүжиг гэсэн 9 номер үзүүллээ.

Цахимаар суралцаж байгаа 47 хүүхдэд цаасаар даалгавар бэлтгэж зөвлөгөө өгөн эргэх холбоотой ажиллаж байна.

Онцгой байдлын 47-р ангиас 6 бүлгийн 117 хүүхдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж өгүүллээ. Хүүхэд хамгааллын тухай сургалтанд 17 багш хамрагдсан.

Мал эмнэлэг: Улсын төсвийн хөрөнгөөр 3-р багийн Хөх чулуут булаг, 6-р багийн Тохой, 4-р багийн Хулстай гэх газруудад “Угаалгын Ванн” шинээр ашиглалтанд орууллаа. Сумын хэмжээнд угаалгын хуучин 8, Малчдын өөрсдийн нөөц бололцоогоор 3, шинээр -3 Бүгд 14 угаалгын ваннтай болоод байна. Гоц халдварт “Үхрийн арьс товруутах өвчин” нь суманд 3 голомтын 8 өрхөд УМЭАЦТЛ-ийн шинжилгээний /21-41-51/ дүнгээр оношлогдон баталгаажсан. 28 хоногийн хугацаанд өвчин дахин илэрээгүй тул 11 сарын 23-ны өдөр хязгаарлалтын дэглэмийг цуцалсан.

Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 34 өрхийн 2495-үхэр, 1155-тугал нийт 3650 мал хамрагдсан байна. Аймгийн мал эмнэлгийн газраас 32,3мян тун вакциныг татан авч, 30725 тун вакцин зарцуулж хэвийн хорогдол 1575 туныг устгав.

Үхрийн арьс товруутах өвчний үеэр ажилласан иргэд, албан хаагчдад олгох томилолт зардлын тооцоо болох 46.0 сая ₮ нөхөн олгох материалыг АОБГ, АМЭГ-т хүргүүлээд байна.

Соёл урлаг: Егүзэрийн харваа шагайн холбоо 11-р сарын 01-22 ныг хүртэл дасгал сургуулилт хийж аймгийн аваргын тэмцээнд оролцууллаа.

Сумын бөхийн холбоо залуучуудын дунд бөхийн Үндэсний бөхийг сурталчлах зорилгоор Бөхийн барилдаан зохион байгуулж 181 хүн үзэж сонихсон, 4-5 настны бөхийн барилдаан зохион байгуулсан. Шатрын тэмцээнийг сумын ИТХ-ын ивээл дор зохион байгууллаа.

ХЦДБ-ийн чуулгын тоглолтыг иргэдэд зориулан тоглуулж 189 хүн үзсэн.

Ахмадын хороотой хамтран ёс заншил өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, сурталчилан таниулах зорилгоор “Үзэмчин түмний жилийн цай уух ёсон” арга хэмжээг амжилттай зохион байгуулж 40 ахмад настан оролцлоо. 11-р сарын 26-нд Улс тунхагласаны баяраар Сумаас төрөн гарсан алдар суутнуудын хөрөг зургийн үзэсгэлэнгийн нээлт “Бүтээлч бүсгүйчүүд клуб”-ын гишүүд 18 бүтээлч бүсгүйчүүдийг урьж санал солилцлоо. оролцлоо. СББӨ тээгч-Бүтээлч бүсгүйчүүд буланг ажиллуулж бүтээлч бүсгүйчүүдийг цувралаар танилцуулан энэ сард Төмөрбаатарын Болорчимэгийг цахимаар олон нийтэд танилцуулан ажиллаж байна. 11-р сарын 29-нд Хутагтын өв соёл урлагийн бага наадмыг 8 багийн дунд зохион байгуулахаар ажиллаж байна.

Соёлын бүтээлч сар аяны хүрээнд: Соёлын яамнаас 21 аймаг 330 сумын Соёлын төвийн ажилчдыг чадавхжуулах сургалтыг зохион явуулсан. Энэхүү сургалтанд Удирдах-1 гүйцэтгэх-3 албан хаагч нийт 4 ажилтан албан хаагч амжилттай хамрагдан суралцаж сертификатаа авлаа. Орчин цагийн номын сан байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээнд соёлын төвийн номын санч болон бусад төлөөлийг оролцуулсан. Соёлын яамнаас зохион явуулсан “Цахим хэрэглээ” сургалтанд 2 ажилтан хамрагдлаа.

Соёлын төвийн стандарт цахим хэлэлцүүлэгт соёлын төвийн дарга хамрагдан санаа бодлоо солилцон хамтран ажиллалаа.

Соёлын өв, бүртгэл мэдээллийн сан, Соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр ажилчид хамрагдаж байна. Эрүүгийн тухай хууль 25-р зүйл Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн талаарх 12 заалтыг танилцуулсан, номын сангаар **22** хүн үйлчлүүлж, гэрээр 25 ширхэг ном олгон ажиллалаа.

Егүзэр хутагт хатагины хар сүлд тахилгын өргөөний халаалтыг шийдвэрлэн үйл энэ сард музейгээр 25 иргэн үүнээс том хүн 11, хүүхэд 14 үйлчлүүлсэн байна.

Тайлан бичсэн:

Тамгын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч

Б.Энхтуяа.